

БАТЛАВ  
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН  
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛЫН ТҮҮХИЙН СОНГОХ ХИЧЭЭЛИЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.05

Хугацаа 80 минут

А хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Сонгох даалгавар 30, оноо 60

Задгай даалгавар 10, оноо 40

Анги:

Сурагчийн нэр:

**Сэргээн санах түвшний даалгавар:**

- Эртний хүмүүс хугадас, таргил үлдэц, хянгар, үзүүр мэс зэрэг хөдөлмөрийн багаж зэвсгүүдийг ямар материалаар хийдэг байсан бэ? /2оноо/  
A. Мод                      B. Яс                      C. Чулуу                      D. Зэс                      E. Хүрэл
- "Монголын өвөг түүх"-ийн үед холбогдох үечлэл аль вэ?  
A. Монголын эртний улсуудын үе                      B. Монголын эзэнт гүрний үе  
C. Чингисийн эрин үе                      D. Нүүдлийн иргэншлийн үе
- Эртний нүүдэлчид яагаад мал аж ахуй эрхэлдэг байсан бэ?  
A. Аль эртнээс эрхэлсэн аж ахуй учраас  
B. Байгаль, цаг уур амьсгалд тохирсон учраас  
C. Газар тариалан эрхлэж мэдэхгүй учраас  
D. Ан гөрөө цөөн учраас
- Монгол нутаг дахь анхны төрт улс?  
A. Сяньби улс                      B. Монгол улс  
C. Хүннү улс                      D. Жужан улс
- VIII-аас XII зууны Монгол аймгуудыг нутаг ус, эрхэлдэг аж ахуйгаар нь хэрхэн хуваадаг вэ?  
A.Ойн анчин, талын малчин                      B.Говийн,Хангайн бүсийнхэн  
C. Зүүн, баруун нутгийнхан                      D. Монгол, Түрэг аймгууд
- Хамаг Монгол аймгийн нутаглаж байсан газрыг нэрлэнэ үү.  
A. Хангай, Хэнтийн уулсын завсраар  
B. Орхон, Сэлэнгийн бэлчрээр  
C. Буйр нуур, Халх голын сав газраар  
D. Туул, Хэрлэн, Онон голын бэлчир, Хэнтийн уулсаар
- Тэмүжин хэдэн онд хаана төрсөн бэ?  
A. 1167 онд Хэнтий аймгийн нутаг Хэрлэнгийн Хөдөө аралд  
B. 1162 онд Хэнтий аймгийн Онон мөрний Дэлүүн болдогт  
C. 1262 онд Хэнтий аймгийн Бурхан Халдун уулын өвөрт  
D. 1206 онд Хэнтий аймгийн Онон мөрний Дэлүүн болдогт
- Улс төрийн бутралын үе аль цаг хугацааг хамрах вэ?  
A. XII-XIII зуун                      B. XIV-XVII- зуун  
C. НТӨ III-Хзуун                      D. 800000-НТӨ III зуун
- Баруун монголын захирдаг тушаалтанг юу гэж нэрлэж байв?  
A. Хаан                      B.Тайш                      C.Чинсан                      D. Хан
- Хүрээ нүүдлийн гол шинж юу вэ?  
A.Эзнээ хүрээлэн бууна.                      B. Харьцангуй суурин шинжтэй.  
C. Малчид бүхлээрээ ноёны харьяат болсон.                      D. Дээрх шинжүүд бүгд холбогдоно.

**Ойлгох түвшний даалгавар:**

- Эртний хүмүүс хайргаар зэвсэг хийхдээ бэлдцээс үлдэц, цуулдас гаргах аргыг олсон нь ..... бүтээх үндсэн арга болж хөгжив.  
A. хүрэл зэвсэг                      B. төмөр зэвсэг                      C. модон зэвсэг                      D. чулуун зэвсэг
- Эртний хүмүүс өөрсдийн амьдралд болсон онцлог үйл явдлыг модны холтос, үйс арьс чулуу зэрэг дээр бичиж тэмдэглэж үлдээснийг түүхийн ямар эх сурвалжид хамааруулан үздэг вэ?  
A. Бичгийн                      B. Аман                      C. Эд өлгийн                      D. Биологийн
- Дээд палеолитод холбогдох анчдын бууц суурин манай улсын бүх нутгаас олддог бол доорх хариултаас үл хамаарах сонгоно уу?  
A. Өвөрхангай Мойлтын ам                      B. Баянхонгор Хойд Цэнхэрийн агуй  
C. Тамсагбулангын суурин                      D.Дээрх бүгд зөв
- Хүннү гүрний цаг уур, газар нутгийн онцлогийг зөв тодорхойлсон нь аль вэ?

- A. Эх газрын чийглэг, эрс тэс уур амьсгалтай, нам дор газар, далайн эрэгт олон арлаар хүрээлэгдсэн  
 B. Эх газрын чийглэг, дулаан уур амьсгалтай, нам дор газар, ихэнх газар нь ой модоор хүрээлэгдсэн.  
 C. Эх газрын хуурай, дулаан уур амьсгалтай, өндөр уулс, далайн эрэгт байрладаг.  
 D. Эх газрын хуурай, эрс тэс уур амьсгалтай, өндөр уулс, хээр тал, говь цөл хосолсон.
15. НТӨ 198 оны гэрээгээр Хүннү ба Хань улсын хил хаагуур тогтсон бэ?  
 A. Урт Цагаан хэрэм                      B. Ордосын Бор тохой  
 C. Шар мөрөн                                D. Хянганы нуруу
16. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг аль вэ?  
 A. Монгол угсаатныг нэгэн төрийн жолоонд оруулсан  
 B. Монголчууд овог, аймгаараа амьдрах болсон  
 C. Эрийн гурван наадмыг санаачлан, монголчуудыг соёлын хувьд нэгтгэсэн  
 D. Өрнө дорныг холбосон эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлсэн
17. Их Юань улстай холбоотой үйл явдал аль вэ?  
 A. 1260 онд Пагва лам улсын багшаар өргөмжлөгдөв.  
 B. Ноёд, язгууртнууд Өзбег хааны үеэс Лалын шашинд оров.  
 C. Кебек хаан улсдаа шинэчлэл хийв.  
 D. Исмалайтыг довтлон Багдадын халифт улсыг мөхөөв.
18. Бурхны шашин Монголчуудын оюуны санааны цөм болсныг аль нь илэрхийлж байна вэ?  
 A. Монголын эрх баригчид улсынхаа нэгдмэл байдлыг сэргээхийн тулд шашин дэлгэрүүлсэн.  
 B. Монголын эрх баригчид Төвөдөд нөлөөгөө тогтоохын тулд шашныг ашигласан.  
 C. Монголд бурхны шашны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхийн тулд өрсөлдсөн.  
 D. Монгол нутагт Энэтхэг, Төвөдийн шашны ном судрыг монголчлох ажил эрчимтэй хөгжсөн.
19. Батмөнх даян хааны төр барьсан 40 шахам жилд тэмцэл, дайн дажин, гадаадын довтолгоо намжсаныг түүхэнд юу гэж нэрлэсэн бэ?  
 A. Гар газар, хөл хөсөр байсан үе                      B. Гэдэс цатгалан байсан үе  
 C. Цаглашгүй их жаргалангийн үе                      D. Төрт ёс сэргэсэн үе
20. Монголчууд Манжид эзлэгдсэн нь бидэнд ямар сургамж үлдээснийг зөв тайлбарласныг сонгоно уу.  
 A. Эв нэгдэл, хүчирхэг захиргаа, эх оронч үзэл, ард түмнээ гэсэн сэтгэл зүрхтэй байх  
 B. Эв нэгдэл, хүчирхэг хаан, эдийн засгийн сул тал, нэгдсэн засаглалтай байх  
 C. Эв нэгдэлгүй бол нэгдсэн захиргаа задарч бусдын дарлал мөлжлөгт өртөж байсан  
 D. Хүчирхэг эдийн засаг, өөрсдөө үйлдвэрлэгч байж бусад улсаас хараат байх

**Хэрэглэх түвшний даалгавар:**

21. Дараах өгөгдлийг зөв холбоорой. /2 оноо/  
 1. Бичгийн сурвалж                      а. Үлгэр, домог  
 2. Эдийн сурвалж                        б. Хадны сүг зураг  
 3. Аман сурвалж                         в. Хувцас, гоёл чимэглэл  
 A. 1а 2б 3в                                B. 1б 2а 3в                                C. 1б 2в 3а                                D. 1в 2а 3в
22. НТӨ 198 онд Хүннү, Хань улсын гэрээ байгуулагджээ. Хэддүгээр зуун, хэддүгээр мянган бэ? /2 оноо/  
 A. НТӨ II зуун, I мянган                                B. НТӨ III зуун, II мянган  
 C. НТ II зуун, I мянган                                D. НТӨ I зуун, I мянган
23. Жужан улсын задралын үеийн Монголчуудаас үүссэн овог аймгийг зөв харгалзуулаарай. /2 оноо/  
 1. Түрэг, Уйгарын захиргаан дахь монголчууд                      а. Боржигин  
 2. Эргүнэ гүний монголчууд    б. Найман, Мэргэд, Хэрэйд  
 3. Хөлөн, Буйр нуурын сав дахь монголчууд    в. Татар  
 4. Цагаан хэрмийн хойгуур орших монголчууд    г. Онгуд  
 A. 1г 2б 3в 4а                                B. 1в 2а 3б 4г                                C. 1б 2в 3г 4а                                D. 1б 2а 3в 4г
24. 2016 оныг билгийн тоололд шилжүүлнэ үү. /2 оноо/  
 A. 17 жаран 30 он гал бичин жил  
 B. 16 жаран 6 он модон гахай жил  
 C. 6 жаран 30 он шороон хонь жил
25. "Пакс Монголика" гэдгийг тайлбарлана уу. /2оноо/  
 .....
26. Чингис хааны өөрийн биеэр эзэлсэн улсуудыг эзэлсэн хугацаагаар зөв дараалалд оруусныг олно уу. /2 оноо/  
 A. Алтан улс, Тангуд, Алтан ордны улс, Хорезм  
 B. Хар кидан, Тангуд, Хорезм, Алтан улс  
 C. Хар Кидан, Хорезм, Тангуд  
 D. Алтан ордны улс, Сартуул, Алтан улс, Тангуд улс

27. XIV-XV зууны үеийн засаг захиргааны бүтцийг хамгийн багаас нь эхлэн зөв дараалалд оруулна уу. /2 оноо/
- A. Түмэн-аймаг-отог  
B. Отог-түмэн-аймаг  
C. Отог-аймаг-түмэн  
D. Отог-хошуу-түмэн
28. Улс төрийн бутралын үед монголыг хэрхэн нэрлэдэг байсан бэ? /2 оноо/
- A. 40 түмэн монгол, 4 түмэн ойрад  
B. 6 түмэн монгол 4 түмэн ойрад  
C. 4 түмэн монгол 6 түмэн ойрад  
D. 4 түмэн монгол 40 түмэн ойрад
29. Монгол Ойрадын хууль буюу Дөчин-Дөрвөн хоёрын цаазыг 1640 онд батлав. Он цагийг шилжүүлнэ үү. /2 оноо/
- A. XIV зууны II хагас  
B. XVII зууны I хагас  
C. XVI зууны I хагас  
D. XVII зууны II хагас
30. Монголд Буддын шашин гурван удаа дэлгэрсэн. Гурав дахь удаагийн буюу XVI зууны II хагасаас дэлгэрсэн шашин нь эхний хоёр дэлгэрэлтээс юугаараа онцлог байсан бэ? /2 оноо/
- A. Нийтийг хамарч чадаагүй  
B. Бурхны шашны улааны урсгал дэлгэрсэн.  
C. Зөвхөн ордны хэмжээнд язгууртны дунд дэлгэрсэн.  
D. Бурхны шашны шарын урсгал, нийтийг хамран дэлгэрсэн.

**Задлан шинжлэх:**

Дараах эх сурвалжийг анхааралтай уншаад, 31, 32-р даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Эх сурвалж 1.

**СУРВАЛЖ**

Дорнод аймгийн нутгаас олдсон неолитын оршуулгын дурсгалууд. Тамсагбулагийн нэгэн сууцны шалан дороос 15 орчим насны, 1,2 м өндөр, монголожуу төрхийн эмэгтэйд агийлган суулгаж, чулуун ир суулгасан ясан хутга, амьтны шүдээр хийсэн хүзүүний зүүлт, гоёлын суус дагалдуулж оршуулсан булш олджээ. Хүнийг үүн шиг суулгаж оршуулсан булшнууд Дорнод аймгийн хэд хэдэн газраас олдсон юм. Тэдгээрээс Буглан сумын Норовлин уулын булш илүү олон ад зүйлстэй байжээ. Норовлингийн булшнд 3000 гаруй суус, хүний нүүр сийлсэн чулуун онго, чулуун ир шийтгэсэн ясан хутга, амьтны шүд халхсан хүзүүний зүүлт, ясан бугуйвч зэрэг гоёлын зүйлс болон чулуун зэвсгүүд дагалдуулжээ.



31. Неолитын үед нас барсан хүний булшнаас ямар ямар эд зүйлс гарсныг тоочиж, яагаад эд зүйлсийн хамт оршуулдаг байсан талаар таамаглал дэвшүүлнэ үү. /4 оноо/

Эд зүйл:

.....

Таамаглал:

.....

.....

32. Неолитын үеийн булшнууд хаанаас олдсоныг тоочиж, яагаад суугаа оршуулж байсныг дүгнэж бичээрэй. /4 оноо/

Хаана:

.....

Дүгнэлт:


.....

.....

.....

Дараах мэдээллийг анхааралтай уншаад, 33, 34, 35-р даалгаврыг гүйцэтгэнэ үү

33. Хүннүгийн үеийн эрхлэх аж ахуйг доорх бүдүүвчид гүйцээн бичнэ үү. /4 оноо/
- Мэдээлэл -1. Хүннүчүүд мал аж ахуй эрхлэн, жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг. Хүннүчүүдийн малын олонх нь адуу, үхэр, хонь, ямаа байлаа. Эгээд мал гэвэл тэмээ, илжиг, луус юм гэж түүхийн эх сурвалжид тэмдэглэсэн байдаг. Ер нь хүннүчүүдийн сүргийн бүтцийн хувьд бог мал (хонь, ямаа) хамгийн олон дараа нь бод мал орно. Бод малаас хамгийн олон нь адуу, үхэр бөгөөд тэмээ хамгийн цөөн байжээ.*



34. Хүннүгийн үеийн ард түмний аж байдлыг таамаглан бичнэ үү. /4 оноо/

.....

.....

.....

35. Хүннүгийн үеийн хүмүүсийн эрхлэх аж ахуйг одоо үетэй харьцуулан бичнэ үү. /4 оноо/

Тухайн үе	Одоо үе

36. Мэдээллийг судлан Их Монгол улс байгуулагдах болсон түүхэн шаардлагыг тодорхойлно уу. /4 оноо/

Мэдээлэл 2. Тухайн үед Монгол олон аймгууд тархай бутархай бие даан оршиж, байнга хоорондоо газар нутаг, цар хүрээ, нөлөөллийн төлөө тэмцэлдэн байлддаг байв. Мөн хөрш Алтан улс, Тангуд улс, Хар Кидан улсууд эзлэн авах, эдийн засгийн эрх тогтоохоор дайн хийн алба татвар авдаг байжээ.

Дотоод шалтгаан	Гадаад шалтгаан
1.	1.
2.	2.

37. Их Монгол улс байгуулагдсаны түүхэн ач холбогдлыг тоочин бичнэ үү. /4 оноо/

Төр засаг

.....

.....

Нийгэм, аж байдал:

.....

.....

Гадаад харилцаа:

.....

.....

Эдийн засаг:

.....  
.....

38. Дараах мэдээллийг анхааралтай уншаад, тухайн үед Монгол улстай хиллэж байсан улсуудыг нэрлэж, оюуны зураглал хийгээрэй. /4 оноо/  
Мэдээлэл 3. Энэ үед Монгол улсын гадаад орчин тайван биш байв. Монгол улс хойд талаараа Орос улстай хиллэх болсон. Зүүн өмнөдөд Манж нар хүчирхэгжиж, өмнөдөд Мин улс доройтож, баруун өмнөдөд Төвөд нутаглаж байв.

Монгол

39. Эх сурвалжийг анхааралтай уншаад, задлан шинжилж, харьцуулан бичнэ үү. /4 оноо/

*Лигдэн хаан өөрийгөө “дөчин түмэн Монголын эзэн”; Нурхачийг “мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хан” хэмээн нэрлэж байв. (Лигдэн хааны захидлаас)*

*...Цахар хаан чиний илгээсэн бичигт: дөчин түмэн Монгол улсын эзэн баатар Чингис хаан, мөрний гурван түмэн Манж улсын эзэн гэгээн ханд илгээсэн хэмээн бичжээ. Танай дөчин түмэн Монгол улсын олныг над юунд гайхуулна? Би сонсвол танай их нийслэл хотыг Дай Мин улсын Хун-Ү хаанд автагдах үед дөчин түмэн монголыг цөм эзэлж, гагцхүү зургаан түмэн буруулан гарсан хэмээн сонссон. Тэрхүү зургаан түмэн монгол цөм чамд үгүй болой. Ордос нэгэн түмэн, арван хоёр Түмэд нэгэн түмэн, Асуд, Юншээбүү, Харчин нэгэн түмэн, тэрхүү Баруун гарын гурван түмэн улс чамд хамаагүй, өвөрчлөн явах улс болой. Эл Зүүн гарын гурван түмэн улс цөм чиний болой. Гурван түмэн улс бүхий атал дөчин түмэн хэмээн эртний үгээр бардамнаж миний улсыг хомс ганцаар гурван түмэн хэмээн доромжлохыг тэнгэр газар үл мэдэх ёс буй, буюу...”  
(Нурхачаас 1619 онд Монголын хаан Лигдэнд ирүүлсэн бичгээс)*

Монголын Лигдэн хааны бодлого	Манжийн Нурхачи хааны бодлого

40. Монголчууд Манжид эзлэгдсэний түүхэн сургамжийг тэмдэглэнэ үү. /4 оноо/  
Үр дагавар:

Түүхэн сургамж:

### СУРГУУЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИСС

Материал зассан: Багш